

Golomt Capital®

БОНДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ



2025.03.19



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Номад	2026.04.07	5.125%	5.90%
Монгол 27	2027.07.27	3.50%	6.40%
Хүннү	2028.01.19	8.65%	6.35%
Монгол 29	2029.06.05	7.875%	6.43%
Монгол 30	2030.02.25	6.625%	6.70%
Монгол 31	2031.07.07	4.45%	6.72%

Эх сурвалж: Bloomberg

Монгол Улсын Засгийн газар бондуудын өгөөж 5.90%-6.72% хооронд хэлбэлзэж байна.



КОМПАНИЙН БОНД (АМ.ДОЛЛАР)

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Голомт Банк (GLMT)	2027.05.20	11.00%	8.20%
МИК (MIK)	2027.01.18	11.50%	9.75%
MMC	2026.09.13	12.50%	6.85%
DBM	2026.03.07	11.00%	6.95%

Эх сурвалж: Bloomberg

Компанийн ам.долларын бондуудын өгөөж 6.95%-8.20%-ийн түвшинд хэлбэлзэж, эрсдэлийг давж өндөр өгөөж хайж буй хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж байна. Голомт Банк олон улсын зах зээлд жилийн 11%-ийн хүүтэй, 2027.05.20-нд хаагдах 300 сая ам.долларын бондыг амжилттай гаргасан бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаагаар худалдан авах боломжтой хэвээр байна.

ҮХАҮТ ТОП-100 ААН-ийн нэг үндэсний тэргүүлэгч компанийн санал болгож буй ам.долларын бондын захиалга авч байна.

Бондын захиалгад нэгдэх:
<https://golomtcapital.com/forms/bond>

АМ.ДОЛЛАРЫН БОНД

ХҮҮ-11%

Хугацаа

12 сар

Хүү төлөх давтамж

Улирал тутам





АМ.ДОЛЛАРЫН БОНДЫН СУУРЬ МЭДЭЭЛЛҮҮД

АНУ-ын бондын өгөөж шинэ доод түвшинд хүрэв

АНУ-ын бондын өгөөж оны эхнээс хойших шинэ доод түвшинд хүрч, зах зээлд эрсдэлийн мэдрэмж дахин суларлаа.

- 10 жилийн хугацаатай бондын өгөөж 4.40%-аас доош унаж, өнөө өглөөний байдлаар 4.274%-тай арилжаалагдаж байна.


Дэлхий даяар эдийн засгийн өсөлтөд эрсдэл үүсэж, инфляцийн дарамт багасч байгаа нь бондын стратегичдын бодлогыг өөрчилж, 2025 оны эхний хагаст 4-5% хооронд тогтмол байж магадгүй гэж таамаглаж байна.

График 1. АНУ-ын урт хугацаат бондын өгөөж



Эх сурвалж: Tradingview

График 2. АНУ-ын Бодлогын хүү



АНУ-ын бодлогын хүү буурахад одоогийн зах зээл дээр байгаа бондуудын үнэ өсч, өгөөж нь буурна. Мөн шинэ бондууд бага хүүтэй гарна. Энэ нь хөрөнгө оруулагчдад урт хугацааны бонд сонирхох шалтгаан болдог бөгөөд зээл, хөрөнгө оруулалтын идэвхжилд эерэг нөлөө үзүүлж болзошгүй.

АНУ-ын ХНС-ийн бодлогын хүүгийн шийдвэр 2025 оны 3-р сарын 19 өдрийн шөнө зарлагдах бөгөөд хүүг хараахан бууруулахгүй гэсэн хүлээлттэй байна. Харин 6-р сараас хүүг бууруулж эхэлнэ гэсэн таамагтай байна.

Эх сурвалж: JPMorgan.com



БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Биржийн бус зах зээлийн долоо хоногийн арилжааны тойм

Биржийн бус зах зээлд нийт 126,626 ширхэг үнэт цаас арилжаалагдсан бөгөөд 41.5 тэрбум төгрөг, 4.27 сая ам.долларын үнийн дүнтэй байв.

Үүнээс:

- Анхдагч зах зээлд 8,200 ширхэг үнэт цаас арилжигдаж, 8.2 тэрбум төгрөг, 3.4 сая ам.долларын арилжаа хийгджээ.
- Хоёрдогч зах зээлд 118,426 ширхэг үнэт цаас арилжигдаж, 33.3 тэрбум төгрөг, 873.6 мянган ам.долларын арилжаа хийгдсэн байна.


Эх сурвалж: Otc.mn

Биржийн бус зах зээлийн бондын өгөөжийн муруй

Бондын өгөөжийн муруй нь зах зээлд гарч буй бондуудын хугацаа болон өгөөжийн хамаарлыг нь илтгэдэг. Өгөөжийн муруйг дараах зорилгоор ашиглах боломжтой. Үүнд:

- Үнэт цаасны өгөөжийн хувь үнэт цаасны хугацаанаас хамааран хэрхэн ялгаатай тогтож байгааг мэдэх
- Шинээр гаргах үнэт цаасны үнэ ханш, өгөөжийг тогтоох жишиг хувь болох
- Бусад бондын өгөөжтэй харьцуулан шийдвэр гаргах боломжийг олгодог юм.

График 2. Бондын өгөөжийн муруй (2024.10-р сард бодлогын хүү өөрчлөгдсөнөөс хойш)



ТВ, медиа



20.5%

Эрчим хүч



19%

ТАНЫ ХУРИМТЛАЛЫН ШИНЭ БОЛОМЖ БОНД



18-19%

Банк, санхүү



\$11%

Уул уурхай



8665-1177 | 8665-4422 | 8083-6622 | 8888-9183